



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Сэврэй сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/079/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Өмнөговь аймаг
2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал:
Г.Энхмаа
Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт	8
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.24 № 101
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
А.ТЭРБИШ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Сэврэй сумын соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13,155.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 781.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайланд онд улсын төсвөөс 219,081.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 120,463.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт авсан байна.

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 13 зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэн 80 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626050126

F:\2.Бичиг хэрэг\2026\01\СТА-н дүгнэлт\Төсөл.Докх

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4	-	-
Кассад байгаа бэлэн мөнгө			
АВЛАГА	5	-	-
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР			
БАРАА МАТЕРИАЛ	6	45,126,706.13	43,227,841.83
Түүхий эд материал		20,501,506.13	20,022,641.83
Тусгай зориулалттай материал		20,501,506.13	20,022,641.83
Хангамжийн материал		24,625,200.00	23,205,200.00
Бичиг хэргийн материал		813,700.00	923,700.00
Бусад хангамжийн материал		23,811,500.00	22,281,500.00
НӨӨЦИЙН БАРАА			
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		45,126,706.13	43,227,841.83
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	943,079,763.33	867,784,028.31
Биет хөрөнгө		940,197,763.33	864,902,028.31
Барилга, байгууламж		809,366,978.47	809,366,978.47
Хуримтлагдсан элэгдэл		(149,765,664.34)	(170,457,160.21)
Машин, тоног төхөөрөмж		264,394,550.00	250,448,510.00
Хуримтлагдсан элэгдэл		(87,696,123.07)	(115,810,191.64)
Тавилга, аж ахуйн эд хогшил		73,259,400.00	68,930,920.00
Хуримтлагдсан элэгдэл		(18,449,013.78)	(26,384,664.40)
Бусад үндсэн хөрөнгө		16,000,000.00	16,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(3,047,868.03)	(3,447,867.99)
Түүх соёлын дурсгалт зүйлс		14,789,500.00	14,789,500.00
Номын фонд		21,346,004.08	21,466,004.08
Бусад биет бус хөрөнгө		2,882,000.00	2,882,000.00
БУСАД ХӨРӨНГӨ	8	2,882,000.00	2,882,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		943,079,763.33	867,784,028.31
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		988,206,469.46	911,011,870.14
Богино хугацаат өр төлбөр			
Өглөг	9	-	686,738.48
Ажиллагчидтай холбогдсон өглөг			686,738.48
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	686,738.48
Урт хугацаат зээл	10		
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН			
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	686,738.48
Засгийн газрын хувь оролцоо		1,034,300,485.46	953,263,847.66
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		844,347,548.70	844,347,548.70
Хуримтлагдсан үр дүн		189,952,936.76	108,916,298.96
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		1,034,300,485.46	953,263,847.66
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		1,034,300,485.46	953,950,586.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		316,154,697.07	339,544,800.00
Улсын төсвөөс		208,341,697.07	219,081,800.00

Өмнөговь аймгийн Сэврэй сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн төсвөөс		107,813,000.00	120,463,000.00
Бараа, үйлчилгээний орлого		147,079,473.44	72,275,497.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		7,685,000.00	3,875,500.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		41,532,473.44	54,463,477.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		67,477,473.44	58,338,977.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		75,428,000.00	13,936,520.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		4,174,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	463,234,170.51	411,820,297.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>		202,332,975.49	250,001,049.22
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		180,285,364.92	222,754,744.52
Цалин		122,549,980.87	138,576,599.15
Нэмэгдэл зардал		51,251,777.14	70,393,404.19
Унаа хоолны хөнгөлөлт		2,796,500.00	
Урамшуулал		3,687,106.91	13,784,741.18
Нийгмийн хамгааллын шимтгэл		22,047,610.57	27,246,304.70
Тэтгэврийн даатгалын шимтгэл		15,125,450.60	18,944,712.55
Тэтгэмжийн даатгалын шимтгэл		1,973,340.00	1,874,592.18
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		822,200.00	821,481.35
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		822,200.00	1,021,481.49
Эрүүл мэндийн даатгалын хураамж		3,304,419.97	4,584,037.13
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>		244,469,015.36	240,493,177.15
Тогтмол зардал		99,668,618.04	99,166,496.42
Гэрэл цахилгааны зардал		2,155,624.44	1,653,486.82
Түлш, халаалтын зардал		95,813,009.60	95,813,009.60
Цэвэр, бохир усны зардал		1,699,984.00	1,700,000.00
Үйл ажиллагааны зардал		112,779,903.00	118,821,910.89
Бусад бараа үйлчилгээний зардал			3,286,764.30
Бичиг хэргийн материал		1,048,500.00	1,735,000.00
Тээвэр, шатахууны зардал		999,600.00	1,600,000.00
Шуудан холбооны зардал		1,165,100.00	750,000.00
Дотоод томилолтын зардал		1,218,000.00	1,096,000.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал		2,001,300.00	8,760,700.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал		125,000.00	200,000.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд		2,185,000.00	
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		2,518,080.00	965,900.00
Бусад зардал		6,480,000.00	7,588,500.00
Элэгдлийн зардал		95,039,323.00	92,839,046.59
<u>Хөтөлбөр арга хэмжээний зардал</u>		32,020,494.32	22,504,769.84
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		760,500.00	1,597,700.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			8,004,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		6,965,000.00	
Бусад урсгал шилжүүлэг			12,903,069.84
Төвлөрүүлэх шилжүүлэг		24,294,994.32	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3	446,801,990.85	490,494,226.37

Өмнөговь аймгийн Сэврэй сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		16,432,179.66	(78,673,929.37)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		-	2,362,708.43
Хөрөнгө худалдсаны гарз			2,362,708.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		-	(2,362,708.43)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		16,432,179.66	(81,036,637.80)
Хяналтын хувь оролцоонд хамаарах үр дүн			
Хяналтын бус хувь оролцоонд хамаарах үр дүн			

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	316,154,697.07	339,544,800.00
Улсын төсвөөс	208,341,697.07	219,081,800.00
Орон нутгийн төсвөөс	107,813,000.00	120,463,000.00
Бараа, үйлчилгээний орлого	49,217,473.44	58,338,977.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	7,685,000.00	3,875,500.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,532,473.44	54,463,477.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	365,372,170.51	397,883,777.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	202,332,975.48	249,314,310.74
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	180,285,364.92	222,754,744.52
Цалин	116,929,355.74	138,924,228.15
Цалингийн тусгай нэмэгдлүүд	63,356,009.18	83,830,516.37
Нийгмийн хамгааллын шимтгэл	22,047,610.56	26,559,566.22
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	18,743,190.60	21,975,529.09
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,304,419.96	4,584,037.13
Бараа, үйлчилгээний урсгал зардал	158,723,192.36	142,599,966.26
Тогтмол зардал	99,668,618.04	99,166,496.42
Гэрэл цахилгааны зардал	2,155,624.44	1,653,486.82
Түлш, халаалтын зардал	95,813,009.60	95,813,009.60
Цэвэр, бохир усны зардал	1,699,984.00	1,700,000.00
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	27,034,080.00	20,928,700.00
Бусад бараа үйлчилгээний зардал	2,000,000.00	3,834,000.00
Бичиг хэргийн материал	1,000,000.00	1,000,000.00
Тээвэр, шатахууны зардал	999,600.00	1,600,000.00
Шуудан холбооны зардал	1,165,100.00	750,000.00
Дотоод томилолтын зардал	1,218,000.00	1,096,000.00
Ном, хэвлэлийн зардал	1,000,000.00	
Жижиг эд хогшил худалдан авах зардал	1,235,200.00	948,800.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	500,000.00	200,000.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	2,635,000.00	
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,873,080.00	2,499,900.00
Урсгал засварын зардал	8,408,100.00	9,000,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	32,020,494.32	22,504,769.84
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	760,500.00	1,597,700.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,004,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	6,965,000.00	
Хөрөнгийн		12,903,069.84
Төвлөрүүлэх шилжүүлэг	24,294,994.32	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	361,056,167.84	391,914,277.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,316,002.67	5,969,500.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)		
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	10,619,700.00	5,969,500.00

Өмнөговь аймгийн Сэврэй сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	10,619,700.00	5,969,500.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(10,619,700.00)	(5,969,500.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	(6,303,697.33)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	844,347,548.70	-	189,952,936.76	1,034,300,485.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл				-
Тайлант үеийн үр дүн			(81,036,637.80)	(81,036,637.80)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	844,347,548.70	-	108,916,298.96	953,263,847.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	339,544,800.00	339,544,800.00	-	100.00
Улсын төсвөөс	219,081,800.00	219,081,800.00	-	100.00
Орон нутгийн төсвөөс	120,463,000.00	120,463,000.00	-	100.00
Бараа, үйлчилгээний орлого	58,338,977.00	58,338,977.00	-	100.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	58,338,977.00	58,338,977.00	-	100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	397,883,777.00	397,883,777.00	-	100.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	258,320,700.00	249,314,310.74	9,006,389.26	96.51
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	229,618,500.00	222,754,744.52	6,863,755.48	97.01
Цалин	141,127,200.00	138,924,228.15	2,202,971.85	98.44
Цалингийн тусгай нэмэгдлүүд	88,491,300.00	83,830,516.37	4,660,783.63	94.73
Нийгмийн хамгааллын шимтгэл	28,702,200.00	26,559,566.22	2,142,633.78	92.53
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	24,225,200.00	21,975,529.09	2,249,670.91	90.71
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,477,000.00	4,584,037.13	(107,037.13)	102.39
Бараа, үйлчилгээний урсгал зардал	149,020,600.00	154,538,966.26	(5,518,366.26)	103.70
Тогтмол зардал	111,463,000.00	99,166,496.42	12,296,503.58	88.97
Гэрэл цахилгааны зардал	3,000,000.00	1,653,486.82	1,346,513.18	55.12
Түлш, халаалтын зардал	106,763,000.00	95,813,009.60	10,949,990.40	89.74
Цэвэр, бохир усны зардал	1,700,000.00	1,700,000.00	-	100.00
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	27,475,900.00	26,898,200.00	577,700.00	97.90
Бусад бараа үйлчилгээний зардал	4,677,500.00	4,513,900.00	163,600.00	96.50
Бичиг хэргийн материал	1,060,000.00	1,000,000.00	60,000.00	94.34
Тээвэр, шатахууны зардал	1,600,000.00	1,600,000.00	-	100.00
Шуудан холбооны зардал	900,000.00	750,000.00	150,000.00	83.33
Дотоод томилолтын зардал	1,150,000.00	1,096,000.00	54,000.00	95.30

Өмнөговь аймгийн Сэврэй сумын соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ном, хэвлэлийн зардал	120,000.00	120,000.00	-	100.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	948,800.00	948,800.00	-	100.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	150,000.00		150,000.00	0.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,500,000.00	2,499,900.00	100.00	100.00
Урсгал засварын зардал	14,169,600.00	14,169,600.00	-	100.00
Нормативт зардал	200,000.00	200,000.00	-	100.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	10,081,700.00	28,474,269.84	(18,392,569.84)	282.44
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,484,000.00	8,004,000.00		94.34
Хөрөнгийн бусад зардал		5,969,500.00	5,969,500.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		12,903,069.84	12,903,069.84	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,597,700.00	1,597,700.00	-	100.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	407,341,300.00	403,853,277.00	(3,488,023.00)	99.14
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй.

Аудитаар нийт 5,286.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 4,599.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 686.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Аудитаар илэрсэн 5,286.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 817.9 мянган төгрөгөөр их боловч өргөн тархаагүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Тайлант онд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд 4,337.9 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.1-т “Ажилтан үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн ажил олгогчдоо мэдэгдэх үүрэгтэй”, 57.3.3-т “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84.4.-т “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 4,337.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2: Тайлант онд нэг ажилтны ээлжийн амралтын цалинг олгохдоо 261.3 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам, Нягтлан бодох

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. “Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 261.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

1. Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 686.7 мянган төгрөгийн өртэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*” гэж заасантай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгч байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж өр, төлбөр үүсгэхгүй ажиллах зөвлөмж өглөө.

2. Няравын тайланд бараа материал худалдан авсан болон зарлагадсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно*” 13.7-д “*Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын худалдан авалт болон зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын иж бүрдэлийг хангаж тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

өрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн ажлаас гадуур зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд 4,337.9 мянган төгрөг илүү олгосон байна.	1	4,337.9	1	4,337.9								
Нэг ажилтны ээлжийн амралтын цалинг олгохдоо 261.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1	261.3	1	261.3								
Няравын тайланд бараа материал худалдан авсан болон зарлагдсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй	1	-					1	-				
Тайлант онд 686.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн байна.	1	686.7					1	686.7				
Дүн	4	5,285.9	2	4,599.2			2	686.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үний дүн бүхий зарлагын 12,286.5 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй.	1	12,296.5			1	12,296.5		
Дүн	1	12,296.5			1	12,296.5		